



## ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

**ДЕРИВАТИВ БУЮУ ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ** гэж өөрийн үнэ цэн нь суурь хэрэгслийн үнэ цэнээр тогтоогддог санхүүгийн хэрэгсэл юм.

### ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ДАВУУ ТАЛ



Ханшийн эрсдэлээс хамгаална



Гүйлгээний зардал бага



Эрсдэлээ удирдах боломжтой



Хөшүүрэг болгон ашиглах боломжтой



Хэлбэлзэл багатай харьцангуй тогтвортой



Таамаглалд суурилдаг

### СУЛ ТАЛ



Хөрвөх чадвар бага



Эрсдэл өндөр



Хугацаа дуусах хүртэл цуцлах боломжгүй



Үнэлэхэд хэцүү

ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ нь ИХЭВЧЛЭН ГЭРЭЭ БАЙДАГ.



### ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН ТӨРӨЛ

Своп гэрээ

Форвард гэрээ

Фьючерс гэрээ

Опцион гэрээ



**Своп гэрээ**– талууд мөнгөн төлбөр, авлагыг ирээдүйд тогтоосон цаг хугацаанд солилцохоор тохиролцсон гэрээ юм



**Форвард гэрээ**– арилжаанд оролцогч талууд урьдчилж тохирсон үнээр гэрээнд заасан хөрөнгийг ирээдүйд худалдах, худалдан авахаар тохиролцох ба арилжаа нь ихэвчлэн биржийн бус зах зээл дээр хийгддэг.



**Фьючерс гэрээ**– зохион байгуулалттай биржийн зах зээлээр дамжуулан арилжаанд оролцогч 2 тал урьдчилж тохирсон үнээр гэрээнд заасан хөрөнгийг ирээдүйд худалдах, худалдан авах нөхцөлтэй.



**Опцион гэрээ**– талууд гэрээнд заасан хөрөнгийг тохиролцсон үнээр гэрээнд заасан хугацаанд худалдах, худалдан авахаар гэрээнд заасан ч гэрээний заасан хугацаа болохоос өмнө гэрээнээс татгалзах боломжтой.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО НЬ:



Үнэт цаасны үнэ



Арилжааны индекс



Гадаад валют



Уул уурхайн бүтээгдэхүүн



Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдэд



СУУРИЛСАН ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛТЭЙ ХОЛБОГДОХ  
ХАРИЛЦААГ ХОЛБОГДОХ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИЦУУЛЖ БАЙНА.